



Asian Development Bank

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАР (НӨАТ)



2023 он

ГАРЧИГ

1. НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАР (НӨАТ)	4
1.1 ГАРЫН АВЛАГЫН ЗОРИЛТ	4
1.2 МОНГОЛ УЛСЫН НӨАТ БА ЕРӨНХИЙ ЗАГВАР	5
1.3 НӨАТ-ЫН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ	6
1.4 ТАТВАР НОГДОХ ЗҮЙЛ	7
1.5 НӨАТ ТӨЛӨГЧ БА НӨАТ СУУТГАН ТӨЛӨГЧ	8
1.6 НӨАТ-ЫН ХУВЬ ХЭМЖЭЭ	9
1.7 НӨАТ-ААС ЧӨЛӨӨЛӨГДӨХ БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ	10
1.8 НӨАТ НОГДУУЛАХ ХУГАЦАА	12
1.9 НӨАТ-ЫН ПАДААН, ТӨЛБӨРИЙН ЦАХИМ БАРИМТ	12
1.10 НӨАТ-ЫН ХАСАЛТ	13
1.11 НӨАТ-ЫН БУЦААН ОЛГОЛТ, УРАМШУУЛАЛ	14
1.12 ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ	15
2. ЕВАРИМТ.МН СИСТЕМ БА И-БАРИМТ АППЛИКЭЙШН	16
3. НӨАТ-ЫН ЦАХИМ ТАЙЛАНГИЙН СИСТЕМ	17


1. НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАР (НӨАТ)

1.1. ГАРЫН АВЛАГЫН ЗОРИЛТ

Төсвийн орлогыг тогтвортой эх үүсвэрээр хангадаг, бараа ажил үйлчилгээний борлуулалт, худалдан авалтыг баримтжуулж татварт бүрэн хамруулдаг, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл багатай, өргөн суурьтай, бага зардлаар хураах боломжтой, олон улсын жишигт нийцсэн бүтэц загвартай зэрэг олон эерэг тодотголтой энэ татварыг Монгол улсад анх 1998 онд нэвтрүүлсэн ба түүнээс хойш жил бүр улсын төсвийн орлогын 20-35 хувийг дангаараа бүрдүүлж байна.

Зах зээлийн харилцаа, түүний дотор цахим худалдаа, хил дамнасан ажил үйлчилгээ, төлбөрийн нөхцлийн төрөл зүйл эрс нэмэгдсэнээр НӨАТ ногдуулах, тооцоолол хийх, төлж тайлагнах НӨАТ суутган төлөгчдийн үүрэг, хариуцлага улам нэмэгдсэн.

Хэдийгээр цахим төлбөрийн баримтын E-barimt систем, татварын цахим тайлангийн etax.mta.mn системийн тусламжтайгаар борлуулалт, худалдан авалтын бүртгэл, НӨАТ ногдуулах аргачлал, тооцоолол амар хялбар болсон ч “Татварын боловсрол-2022” зорилтын хүрээнд татвар төлөгчдөд зориулсан энэхүү гарын авлагыг Азийн Хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр боловсруулан хүргэж байна.



1.2. МОНГОЛ УЛСЫН НӨАТ БА ЕРӨНХИЙ ЗАГВАР

- **Нэр:** Нэмэгдсэн өртгийн албан татвар
- **НӨАТ ногдох зүйл:** Бараа, ажил, үйлчилгээний борлуулалт
- **НӨАТ төлөгч:** Худалдан авагч, эцсийн хэрэглэгч
- **НӨАТ суутган төлөгч:** НӨАТ суутган төлж тайлагнах үүрэгтэй этгээд
- **НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлэх босго:** 50 сая төгрөг
(сайн дураар: 10 сая төгрөг)
- **НӨАТ-ын хувь хэмжээ:** 10% ба 0%
- **Гадаад худалдаанд НӨАТ ногдуулах зарчим:** Импортлох үед ногдуулах
- **Тайлан гаргах давтамж:** Сар бүр
- **НӨАТ тайлан гаргах, татвар төлөх хугацаа:** Дараа сарын 10-ны дотор
- **НӨАТ-ын тооцооллын аргачлал:** Падааны арга
- **НӨАТ баримт:** Нэхэмжлэл, төлбөрийн баримт, НӨАТ-ын падаан
- **НӨАТ суутган төлөгчийн дугаар:** 7 оронтой дугаар
- **НӨАТ нэвтрүүлсэн огноо:** 1998 оны 07 сарын 01
- **НӨАТ ногдуулалт төлөлтөд хяналт тавих байгууллага:** Сангийн яам, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар

1.3. НӨАТ-ЫН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

1

Нэмэгдсэн өртгийн
албан татварын
тухай хууль

(2015-12-21)

2

Ашигт малтмалын
эцсийн
бүтээгдэхүүний
жагсаалт

*(Засгийн газрын
тогтоол: Дугаар
502, 2015-12-21)*

3

НӨАТ-ын хасалт
хийх, буцаан олгох,
тэдгээрийг нягтлан
бодох бүртгэлд
тусгах журам
*(Сангийн сайдын
тушаал, Дугаар 333,
2015-12-14)*

4

НӨАТ төлөгчийн
худалдан авалтад
төлсөн нэмэгдсэн
өртгийн албан
татварыг буцаан
олгох журам

*(Сангийн сайдын
тушаал, Дугаар 14,
2020-01-27)*

5

Сугалааны
тохирлоор
урамшуулал олгох,
түүнийг явуулах
журам

*(Сангийн сайдын
тушаал, Дугаар
А/185, 2022-09-09)*

6

НӨАТ суутган
төлөгчийг бүртгэх,
бүртгэлээс хасах
журам

*(ТЕГ-ын даргын
тушаал, Дугаар
А/02,
2020-01-03)*

7

НӨАТ-ын падаан,
падаан хэрэглэх
заавар

*(ТЕГ-ын даргын
тушаал, Дугаар
А/02, 2020-01-03)*

1.4. ТАТВАР НОГДОХ ЗҮЙЛ

Дараах бараа, ажил, үйлчилгээ (БАҮ)-ний борлуулалтад НӨАТ ногдоно.

Борлуулалт	Монгол улсын нутаг дэвсгэрт	Монгол улсаас экспортолсон	Монгол улсад импортолсон
Бараа	НӨАТ ногдоно	НӨАТ ногдоно	НӨАТ ногдоно
Ажил	НӨАТ ногдоно	НӨАТ ногдоно	НӨАТ ногдоно
Үйлчилгээ	НӨАТ ногдоно	НӨАТ ногдоно	НӨАТ ногдоно

	Татварын байгууллага хяналт тавина
	0 /тэг/ хувиар татвар ногдоно
	Reverse charge буюу худалдан авагч НӨАТ ногдуулна. Татварын алба хяналт тавина
	Гаалийн байгууллага ногдуулж хурааж, хяналт тавина.

- “Борлуулалт” гэж барааг бусдын өмчлөлд шилжүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхийг ойлгоно.
- Бараа, ажил, үйлчилгээнд НӨАТ ногдуулахад доор дурдсан нөхцөлийг хангасан байна:
 - Тухайн этгээд нь НӨАТ суутган төлөгчөөр бүртгэгдсэн байх;
 - Борлуулалтыг ашиг олох зорилготой болон зорилгогүйгээр аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд хийсэн байх.
- Дараах үйл ажиллагааг БАҮ борлуулсанд тооцно:
 - Эрх борлуулах
 - Үйл ажиллагаа зогсоох үед өөртөө үлдээсэн бараа
 - Эд мөнгөний хонжворт сугалаа гаргах
 - Өрийн төлбөрийг бараа, ажил үйлчилгээ үзүүлэх замаар хаах
 - Оршин суугч бус этгээдийн оршин суугчид борлуулсан БАҮ
 - Бусдын буруутай ажиллагааны улмаас хүү торгууль алданги авах
 - Төсвөөс олгож байгаа татаас, урамшуулал
 - Шаардах эрхийг худалдах замаар санхүүжилт хийх
 - Өмгөөллийн үйлчилгээ

1.5. НӨАТ ТӨЛӨГЧ БА НӨАТ СУУТГАН ТӨЛӨГЧ

- НӨАТ-ын хувьд “татвар төлөгч” гэдэг ойлголт нь өвөрмөц утгыг агуулна:
 - **Татвар төлөгч** гэж БАҮ борлуулахгүй, хувийн хэрэглээнд худалдан авч, импортолсон хувь хүнийг,
 - **НӨАТ суутган төлөгч** гэж НӨАТ ногдох борлуулалтын хэмжээ нь 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрч, улмаар татварын албанд тусгайлсан бүртгэлд бүртгэгдсэн, НӨАТ ногдуулан суутган авч, төсөвт төвлөрүүлэх, тайлагнах үүрэг хүлээсэн этгээдийг,
- Борлуулалтын хэмжээ 50 сая төгрөгт хүрснээс хойш **10 хоногийн** дотор татвар төлөгч татварын албанд өргөдөл гаргах ба Татварын алба нь **3 хоногийн** дотор НӨАТ суутган төлөгчөөр бүртгэж гэрчилгээ олгоно.
- Дараах хувь хүн, хуулийн этгээд НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлэх үүргээс чөлөөлөгдөнө:
 - Үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь 50 сая ба түүнээс доош,
 - НӨАТ-өөс чөлөөлөгдөх БАҮ дагнан эрхэлдэг,
- **Сайн дураар бүртгүүлэх:** Үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь 10 сая төгрөг ба түүнээс дээш бол хүсэлтээ гарган сайн дураараа НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлж болно.
- **НӨАТ суутган төлөгчийн бүртгэлээс хасах:**
НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлснээс хойш албан татвар ногдох орлогогүй, эсхүл орлогын хэмжээ нь 50 сая төгрөгт хүрээгүй нь дараалсан 12 сарын албан татварын тайлангаар, эсхүл үйл ажиллагаа явуулаагүй нь нотлогдсон бол татварын алба НӨАТ суутган төлөгчийн бүртгэлээс хасч, гэрчилгээг хүчингүй болгоно.
- **Reverse charge rule:** Оршин суугч бүс этгээдээс Монгол улсын нутаг дэвсгэр дээр гаальд мэдүүлээгүй бараа болон бусад ажил үйлчилгээ худалдан авсан бол худалдан авагч-оршин суугч этгээд нь түүний өмнөөс НӨАТ суутган төлөх үүрэг хүлээнэ.

Энэхүү гарын авлагад заасан ерөнхий заавартай танилцсаны дараа хууль тогтоомжийн холбогдох заалттай нарийвчлан танилцах, татварын албанаас зөвлөгөө авах шаардлагатай.

1.6. НӨАТ-ЫН ХУВЬ ХЭМЖЭЭ



- 10 хувь: Үндсэн хувь хэмжээ буюу Монгол улсын нутаг дэвсгэрт борлуулсан болон импортоор авсан бүх БАҮ-нд ногдуулна.

- 0 хувь: Экспортод гаргасан БАҮ-нд 0 /тэг/ хувиар НӨАТ ногдуулна.

- 0-10 хувь: Импортоор оруулсан, эсхүл үйлдвэрлэн борлуулсан автобензин, дизелийн түлшинд ногдох НӨАТ-ын хувь хэмжээг салбарын онцлогийг харгалзан Засгийн газар тогтооно.

- Дараах БАҮ-ий борлуулалт НӨАТ-ын 0/тэг/ хувьд хамаарна:

- Монгол Улсын нутаг дэвсгэрээс экспортод гаргасан, экспортод гаргахаар гаалийн байгууллагад мэдүүлсэн бараа;

- Монгол Улсын Олон улсын гэрээнд заасны дагуу Монгол Улсаас гадаад улсад, гадаад улсаас Монгол Улс хүртэл, түүнчлэн гадаад улсаас Монгол Улсын хилээр дамжуулан бусад улсад гаргасан олон улсын зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ;

- Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна үзүүлсэн үйлчилгээ;

- Монгол Улсад оршин суугч бус этгээдэд үзүүлсэн үйлчилгээ;

- Олон улсын нислэг үйлдэж байгаа агаарын тээврийн хөлөгт үзүүлэх үйлчилгээ;

- Засгийн газар, Монголбанкны захиалгаар дотоодод үйлдвэрлэсэн төрийн одон медаль, мөнгөн тэмдэгт, зоос;

- Экспортод гаргасан ашигт малтмалын эцсийн бүтээгдэхүүн.

- Жишээ: НӨАТ-ын 10 хувь, 0 хувь, чөлөөлөлтийн ялгаа.

Хувь хэмжээ	10 хувь	0 хувь	Чөлөөлөлт
Борлуулалт:	100 төг	100 төг	100 төг
А. НӨАТ	10 төг	0 төг	-
Худалдан авалт:	75 төг	75 төг	75 төг
Б. НӨАТ	7.5 төг	7.5 төг	7.5 төг
Тооцоо /А-Б/	2.5 төг төсөвт төлнө	-7.5 төг Илүү төлөлт	Тооцоо хийхгүй

1.7. НӨАТ-ААС ЧӨЛӨӨЛӨГДӨХ БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

- Дараах **БАРАА** НӨАТ-аас чөлөөлөгдөнө:
 - Гаалиар татваргүй нэвтрүүлэхийг зөвшөөрсөн хувийн хэрэглээний бараа;
 - Гадаадын дипломат төлөөлөгчийн газар, Нэгдсэн үндэсний байгууллага, түүний төрөлжсөн салбарын хэрэгцээнд зориулан импортоор оруулсан бараа;
 - Гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагаас буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламж, хөнгөлөлттэй зээлээр авсан бараа;
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусгай зориулалтын хэрэгсэл, тоног төхөөрөмж, автотээврийн хэрэгсэл;
 - Иргэний агаарын хөлөг, хөдөлгүүр болон газар дээрх дадлагажуур, тэдгээрийн эд анги, бүрэлдэхүүн хэсэг,
 - Орон сууцны зориулалтаар ашиглаж байгаа байр,
 - Эмчилгээний цус, цусан бүтээгдэхүүн, эд эрхтэн;
 - Хийн түлш, түүний сав, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын машин механизм, техник хэрэгсэл, тоноглол;
 - Монголбанкнаас хийлгэсэн мөнгөн тэмдэгт, мөнгөн дэвсгэрт;
 - Борлуулсан алт;
 - Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын туршилтын бүтээгдэхүүн;
 - Экспортод гаргасан ашигт малтмалын бүтээгдэхүүн;
 - Улс хоорондын шуудангийн илгээмж;
 - Газрын тостой холбогдсон машин, техник, материал, химийн болон тэсрэх бодис, сэлбэг хэрэгсэл;
 - Газрын тос;
 - Чөлөөт бүсэд зорчигчийн худалдаж авсан гурван сая төгрөг хүртэл үнийн дүнтэй бараа.

НӨАТ-аас чөлөөлөгдөх зарим барааны жагсаалтыг Засгийн газар тусгайлан баталдаг тул тухайн бараатай холбоотой жагсаалтыг шалгаж үзэх шаардлагатай.

- Банк, банк бус санхүүгийн байгууллага болон бусад хуулийн этгээдээс гаргасан шаардах эрх;
- Үр тариа, төмс, хүнсний ногоо, суулгац, жимс жимсгэнэ, үйлдвэрлэсэн гурил;
- Мах махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн;
- ЖДҮ-ийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл;
- Инновацийн түүхий эд, материал, урвалж бодис;
- Импортын мод, бэлдэц, модон материал;
- Экспортод гаргасан түүхий, угаасан, самнасан ноолуур, арьс шир;
- Соёлын өвийг судалж шинжлэх, сэргээн засварлахад ашиглах материал, техник, тоног төхөөрөмж, бодис, багаж хэрэгсэл;
- Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газрын албан ажлын болон тэдгээрт ажиллагсдын хувийн хэрэгцээнд зориулж худалдан авсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээ;
- Сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг

- **НӨАТ тусгай хувь хэмжээгээр ногдох бараа:**

Засгийн газар нь зэх зээлийн нөхцөл байдалд үндэслэн импортоор оруулах дизелийн түлш, автобензид ногдох НӨАТ-ын хувь хэмжээг 0-10 хувиар тогтоож болно.

- **Дараах ҮЙЛЧИЛГЭЭГ НӨАТ-аас чөлөөлнө:**

- Банк болон банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооны үйлчилгээ;
- Даатгалын үйлчилгээ;
- Үнэт цаас, хувьцаа гаргах, баталгаа гаргах үйлчилгээ;
- Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын сангийн үйлчилгээ;
- Орон сууц хөлслүүлэх үйлчилгээ;
- Боловсролын үйлчилгээ;
- Эрүүл мэндийн үйлчилгээ;
- Шашны байгууллагын үйлчилгээ;
- Төрийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээ.
- Нийтийн тээврийн үйлчилгээ;
- Гадаадын жуулчдад үзүүлсэн /түрөпатор/ үйлчилгээ;
- Соёлын өвийг сэргээн засварлах үйлчилгээ;
- Оршуулгын үйлчилгээ;
- Мал эмнэлгийн үйлчилгээ;
- Нотариатын үйлчилгээ;
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ.

- **“САНГИЙН САЙД, ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ”-аар баталсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-ыг үндэслэн НӨАТ ногдох болон татвараас чөлөөлөх бараа, үйлчилгээг тодорхойлно.**

- **Хасалт:** НӨАТ-аас чөлөөлөгдөх бараа, ажил үйлчилгээ эрхэлсэн бол түүнтэй холбоотой худалдан авсан болон импортолсон бараа ажил үйлчилгээний НӨАТ-ыг хасч тооцохгүй.

1.8. НӨАТ НОГДУУЛАХ ХУГАЦАА

- НӨАТ ногдуулах хугацааг татварын албанаас гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн тооцно.
- НӨАТ ногдуулах хугацааг доор дурдсан үйлдлийн аль түрүүнд хийгдсэн өдрөөр тогтооно:
 - Борлуулагч бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогыг хүлээн авсан өдөр;
 - Бараа, ажил, үйлчилгээг борлуулж төлбөрийн баримт, нэхэмжлэл үйлдсэн өдөр;
 - Бараа, ажил, үйлчилгээг худалдан авсан өдөр.
- Цахилгаан, дулаан, усан хангамж, харилцаа холбооны тогтмол үйлчилгээнд албан татвар ногдуулах хугацааг төлбөрийн баримт үйлдсэн, төлбөрийг хүлээн авсан өдрийн аль түрүүчийнхээр бодож тооцно.
- **Импортын барааг** гаалийн байгууллагад мэдүүлсэн өдрөөр НӨАТ ногдуулах хугацааг тогтооно.
- **Санхүүгийн түрээсийн** хувьд төлбөрийн хуваарийг баримтлан ногдуулна.

1.9. НӨАТ-ЫН ПАДААН, ТӨЛБӨРИЙН ЦАХИМ БАРИМТ


- “НӨАТ-ын падаан” гэж төлбөр тооцоо хийснийг нотлох он, сар, өдөр, татвар төлөгчийн нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, БАҮ-ий нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан цаасан болон цахим баримтыг хэлнэ.
- НӨАТ-ын падаан нь цахим системээс олгогдсон тоон утгаар илэрхийлэгдсэн дахин давтагдашгүй дугаартай байна.
- E-barimt.mn - НӨАТ-ын цахим баримтын системийг ашиглан цахим нэхэмжлэх, төлбөрийн баримт, падаан үйлдэнэ.
- НӨАТ суутган төлөгч борлуулалт хийх бүртээ төлбөрийн баримт, НӨАТ-ын падаан үйлдэнэ.
- НӨАТ-ын падааныг үндэслэн НӨАТ-ын хасалт, буцаан олголт хийгдэнэ.
- Падаан, цахим баримтын бүртгэл тухай бүр нэгдсэн системд бүртгэгдэнэ.
- Гаалийн мэдүүлгийг экспорт, импортын хувьд НӨАТ-ын падаантай адилтган үзнэ.

1.10 НӨАТ-ЫН ХАСАЛТ


- Монгол улсын НӨАТ-ын тогтолцоо нь падааны аргад суурилсан тул цахим системд бүртгэгдсэн цахим НӨАТ-ын падаан, гаалийн мэдүүлгийг үндэслэн хасалт хийнэ:
 - Монгол Улсад үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар худалдан авсан БАҮ-нд төлсөн;
 - Худалдах болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар импортоор оруулсан бараанд төлсөн;
- НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлэхээр өргөдөл гаргасан өдрөөс хасалт хийх эрх үүснэ.
- Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн анхан шатны боловсруулалтад ороогүй мах, сүү, өндөг, арьс шир, хонь, тэмээний ноос, ноолуур, сарлагийн хөөвөр, мах боловсруулах үйлдвэрлэлд зориулан бэлтгэх таван хошуу мал, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ болон дотооддоо үйлдвэрлэсэн гурилыг дотоодын үйлдвэрлэгчдэд борлуулсан бол үнийн дүнд нь 10 хувийн албан татвар шингэсэн гэж үзэж хасалт хийнэ.
- Үндсэн хөрөнгийн худалдан авалтын НӨАТ-ыг дараах хугацаанд хувааж хасалт хийнэ:



Барилга, байгууламж 10 жилээр /120 сар/



Тоног төхөөрөмж, хайгуулын зардал
5 жилээр /60 сар/



Бусад хөрөнгийн хувьд шүүд хасалт хийнэ

- Дараах худалдан авалтын НӨАТ-ыг борлуулалтад ногдсон НӨАТ-аас хасахгүй:
 - Суудлын автомашин, түүний эд анги, сэлбэг
 - Хувийн болон ажиллагсдын хэрэгцээнд зориулсан БАҮ
 - НӨАТ-аас чөлөөлөгдөх үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулж импортолсон болон худалдаж авсан БАҮ
 - Тайлант хугацаанд хамааралгүй БАҮ
 - Ашиглалтын өмнөх үйл ажиллагаанд зориулж импортоор оруулсан болон худалдан авсан БАҮ
 - Оршин суугч бус этгээдээс суутгасан НӨАТ
- НӨАТ-тай худалдан авалтыг НӨАТ ногдох болон чөлөөлөгдөх үйл ажиллагаанд зэрэг ашигласан бол хасалтыг хувь тэнцүүлэн тооцно.
- НӨАТ-ын падаан бол НӨАТ-ын хасалт хийх үндсэн баримт болно.

1.11. НӨАТ-ЫН БУЦААН ОЛГОЛТ, УРАМШУУЛАЛ

- НӨАТ-ын хуульд зааснаар дараах буцаан олголт, урамшуулал олгогдоно:

1. НӨАТ суутган төлөгчид илүү төлөлтийг буцаан олгох. Тухайн сард хийх хасалтын хэмжээ нь мөн хугацаанд төлбөл зохих албан татварын дүнгээс их байвал түүнийг илүү төлөлт гэж нэрлэнэ. НӨАТ суутган төлөгчийн тайлангаар гарсан илүү төлөлтийг:

- Дараагийн сар, улирал, жилд төлөх татварт шилжүүлэн тооцох
- Бусад татварын төлбөрт шилжүүлэн тооцох
- Татвар төлөгчид буцаан олгож болно

- Илүү төлөлтийг буцаан олгоход баталгаажуулах шалгалт хийнэ.
- Илүү төлөлтийг буцаан авах, бусад татварын өрөнд суутгуулах хүсэлт гаргаснаас хойш татварын алба ажлын 22 хоног багтаан баталгаажуулалт хийнэ.
- Баталгаажсан илүү төлөлтийг Сангийн яам ажлын 45 хоног багтаан буцаан олгоно.
- Экспортлогчид сар бүр, бусад татвар төлөгчид улиралд 1 удаа буцаан олголт олгоно.

2. НӨАТ төлөгчид урамшуулал олгох. НӨАТ төлөгч-хэрэглэгч- хувь хүний худалдан авалтад төлсөн НӨАТ-ын 20 хувийг улирал бүр буцаан олгоно.

3. Сугалааны тохирол. НӨАТ-тай худалдан авалтын дугаараар, сугалааны тохирлыг сугалааны машинаас найман /8/ бөмбөлөг санамсаргүй байдлаар тус тус үлээлгэн гаргах замаар хөндлөнгийн хяналтын дор зохион байгуулна. Бөмбөлгийн дугаарлалт нь тэг /0/-ээс ес /9/ хүртэлх арван /10/ цифрээс бүрдэнэ.

- Сугалааг сар бүр зохион байгуулна.

4. Дипломат төлөөлөгчийн болон консулын газрын албан ажлын болон тэдгээрт ажиллагсдын хувийн хэрэгцээнд зориулж Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн НӨАТ-ыг сар бүр буцаан олгоно.

1.12. ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ

- **Татварын ерөнхий хуульд** (84-р зүйл) зааснаар хууль тогтоомж зөрчсөн татвар төлөгчид дараах хариуцлага хүлээлгэнэ:
 - 1. Төсөвт төлөх татварын хэмжээг бууруулсан буюу төлөөгүй** бол төлбөл зохих татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлөх татварын дүнгийн 40 хувиар торгоно.
 - 2. НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлэлгүй** бараа үйлдвэрлэсэн, борлуулсан, ажил, үйлчилгээ үзүүлсэн бол татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлөх татварын дүнгийн 40 хувиар торгоно.
 - 3. Ажил, үзүүлсэн үйлчилгээндээ НӨАТ ногдуулаагүй** бол НӨАТ суутган төлөгчөөр татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлөх татварын дүнгийн 40 хувиар торгоно.
 - 4. НӨАТ суутган төлөгч ногдуулсан НӨАТ-аа төлөөгүй бол** татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлөх татварын дүнгийн 40 хувиар торгоно.
 - 5. Зөрчлийг давтан үйлдвэл:** Өмнө нь татварын албаны хяналт шалгалтаар илрүүлж нөхөн ногдуулалтын актаар тогтоосон тухайн зөрчлийг дахин давтсан бол нөхөн төлбөл зохих татварын дүнгийн 50 хувиар торгоно.
- **Зөрчлийн тухай хуульд** (11.19-р зүйл) зааснаар дараах хариуцлага хүлээлгэнэ:
 - 1. Татварыг хуулиар тогтоосон хугацаанд нь төлөөгүй** бол хүн, хуулийн этгээдийг хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөгдөөгүй татварын 0.1 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
 - 2. Төлбөрийн баримт олгоогүй бол** өмнөх тайлант сарын хугацаанд олсон орлогын үнийн дүнгийн 2 хувиар торгоно.
 - 3. Төлбөрийн баримтыг борлуулалтын үнийн дүнгээс зөрүүтэй олгосон** бол өмнөх тайлант сард олсон орлогын үнийн дүнгийн 20 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.


Е-BARIMT.MN систем ба И-Баримт аппликэйшн




- НӨАТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2016 оны 1-р сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээр НӨАТ-ын цаасан падааныг цахим хэлбэрт шилжүүлэн цахим төлбөрийн баримт гаргах ebarimt.mn системийг хөгжүүлсэн.

Энэхүү системийн тусламжтайгаар:

- Хувь хүн, хуулийн этгээдүүд цахим бүртгэлийн системээр дамжуулан борлуулалт, худалдан авалтын цахим нэхэмжлэх, төлбөрийн баримт, НӨАТ-ын падаан үйлдэх боломжтой.
- НӨАТ-ын тайланг татвар төлөгчийн оролцоогүйгээр тодорхойлох боломж нээгдсэн.
- И-Баримт аппликэйшнд гар утаснаас хандахад дата үнэ төлбөргүй бөгөөд төлбөрийн баримтаа хэзээ ч, хаанаас ч бүртгүүлэх боломжтой.
- Facebook мессенжерээр И-Баримт хувийн чатад нэгдсэнээр НӨАТ-ын буцаан олголт, сугалааны урамшуулал болон И-Баримт-ын талаарх мэдээллийг цаг алдалгүй, түргэн шуурхай 24 цагийн түрш авах боломжтой.
- Өөрийн бүртгэлийн бар кодыг ашиглан хялбараар худалдан авалтын баримтаа бүртгүүлэх боломжтой.
- Бүртгэгдсэн баримтын ангиллыг ухаалгаар хуваарилж, урамшууллын дүнг баримт тус бүрээр харж болно.
- QR кодоор бүртгүүлсэн баримт “ААН ИЛГЭЭГЭЭГҮЙ” төлөвт шилжсэн тохиолдолд гомдлыг гар утасны аппликэйшнаар гаргах боломжтой.
- Хялбаршуулсан горимоор тайлан илгээх, татвараа төлөх, төлсөн татвар болон үйл ажиллагааны орлого, зарлагын дүнгээ хүссэн үедээ харах боломжтой.
- Төрийн үйлчилгээний төлбөр тооцоог И-Баримт аппликэйшнаар 1-3 минутад төлөх боломжтой.
- И-Баримт аппликэйшнд бүртгэлтэй дансны дугаараар халамжийн үйлчилгээг авч болно.
- Нийгмийн халамжийн 4 төрлийн үйлчилгээг И-Баримт аппликэйшн ашиглан өөрийн биеэр банканд дугаарлахгүй, цаг хугацаа алдахгүйгээр иргэд өөрийн харилцах дансандаа авах боломжтой болсон. Үүнд:



Насны хишиг



I, II зэргийн одонтой
эхэд олгох мөнгөн
тусламж



Жирэмсэн эхийн
тэтгэмж



0-3 насны хүүхэд
асарсны тэтгэмж

3.

НӨАТ-ЫН ЦАХИМ ТАЙЛАНГИЙН СИСТЕМ

- НӨАТ суутган төлөгч нь Татварын ерөнхий хуулийн 28-р зүйлд зааснаар төлбөл зохих татвараа өөрөө тодорхойлж, хуулиар заасан хугацаанд төсөвт төлөх үүрэгтэй.
 - Татварын цахим тайлангийн систем нь НӨАТ-ын тайланг бүртгэлийн системд бүртгэгдсэн мэдээллийн тусламжтайгаар шууд тодорхойлж гаргах боломжтой.
 - НӨАТ-ын цахим тайланг дараах дарааллаар бэлтгэж хянаж илгээх боломжтой.
1. Цахим төлбөрийн баримтын системд бүртгэгдсэн борлуулалт, худалдан авалтын баримт, алдаатай баримт, засагдсан баримт, зөрчилтэй баримт, баталгаажуулан буцаалтаа хянана.
 2. Тайлангийн мэдээ хэсгээр нэвтэрч, экспорт, импортын гаалийн мэдээгээ татна.
 3. Тайлангийн мэдээ хэсгийн борлуулалт, худалдан авалтын бүртгэлийн мэдээ ТТ-03А маягтын 5-6-р мөр идэвхгүй болж системээс нөхөгдөх тул төлбөрийн баримт бүртгэхдээ баримт шивэх цэсийг зөв сонгож хэрэглэнэ. Тухайлбал, төлбөр төлөгдөөгүй борлуулалтыг зөвшөөрөхөд нэхэмжлэх үүсгэх, төлбөр төлөгдсөн тухай бүр төлөгдсөн дүнгээр төлбөрийн баримт үүсгэнэ.
 4. Зохих тохируулга хийсний дараа системд тайлангаа **хадгална**.
 5. **Шинэчлэх** товч дарж мэдээг татсанаар тайлангийн үзүүлэлтүүд нөхөгдөж тайлан бэлтгэгдэнэ.
 6. Үзүүлэлтүүд тохирч байгаа бол **Хадгалах** товч дарж, улмаар баталгаажуулан **Илгээх** товчоор тайлангаа илгээнэ.

